



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/81

Булган сум

┌ Монгол улсад орчин цагийн Зэвсэгт хүчин ┐  
үүсч байгуулагдсаны 103 жилийн ойг тэмдэглэх тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, 17.1.10, Батлан хамгаалах зарим чиг үүргийг Булган аймагт төлөөлөн 2024 онд хэрэгжүүлэх гэрээний 1.5, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчин үүсч байгуулагдсаны түүхт 103, Халх голын дайны ялалтын 85 жилийн ойг тусгай төлөвлөгөө гаргаж, шаардагдах хөрөнгийг хавсралтаар баталж тэмдэглэн өнгөрүүлсүгэй.

2. Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 103, Халх голын байлдааны ялалтын 85 жилийг тохиолдуулан Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын дунд аймгийн Засаг даргын нэрэмжит "Марш тактик-тусгай бэлтгэл"-ийн аварга тасаг шалгаруулах тэмцээнийг 2024 оны 03 дугаар сарын 13-14-ний өдөр Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийг түшиглэн сахилга, зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг Цэргийн штаб (дэд хурандаа Ч.Энхбаяр), Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийн захирагч (Хурандаа Г.Эрдэнэбаяр)-т хариуцуулсугай.

3. Тэмцээнүүдийн шагналын зардал 6,700,000 (зургаан сая долоо зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс хавсралтын дагуу зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



БАРИУН-ЭРДЭНЭ

Com.D.Tushaal2024

• 632401010

Аймгийн Засаг даргын 2024 оны  
02 дугаар сарын 20-ны өдрийн  
А/8 дугаар захирамжийн хавсралт

**ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ**

№	Зардлын чиглэл	Хөрөнгийн хэмжээ	Бүгд
1	“Марш тактик-тусгай бэлтгэл”-ийн аварга шалгаруулах тэмцээний зардал	3.640.000	1-р байр 1.000.000 2-р байр 800.000 3-р байр 600.000 Өргөмжлөл 5*80.000=400.000 Медаль 33ш*20.000=660.000 Буудлагын тэмцээний медаль 9*20.000=180.000
2	Зэвсэгт хүчний 103, Халх голын байлдааны 85 жилийн ойн нэрэмжит насанд хүрэгчид, өсвөр үеийн аварга шалгаруулах хийн буудлагын тэмцээний зардал	1.060.000	1-р Байр 4*50.000=200.000 2-р Байр 4*40.000=160.000 3-р Байр 4*30.000=120.000 Шүүгч 2хүн 40.000=80.000 Сум 2 хайрцаг 500.000 Нийт – 1.060.000
3	Монгол улсад хурандаа цол үүссэний 88 жилийн ойг тохиолдуулан Булган аймагт ажиллаж амьдарч байгаад бэлтгэл, чөлөөнд гарсан “Хурандаа” нарт хүндэтгэл үзүүлэх	1.500.000	Гарын бэлэг хүн 15ш*50.000=750.000 Хүндэтгэлийн зоог, 15хүн*50.000төг=750.000
4	Дайнд оролцсон ахмад дайчинд хүндэтгэл үзүүлэх	500.000	Дашинчилэн сум Данзан Дорж
БҮГД			6.700.000